



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1992 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 4/60.

Улаанбаатар хот

"Дугуй" компанийг татан
буулгах тухай.

Нэг. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны "Дугуй" компанийг 1992 оны 12 дугаар сарын 15-наас татан буулгаж, Монголын талын хөрөнгө оруулагчийн эрхийг хотын Тээврийн газарт шилжүүлсүгэй.

Хоёр. "Дугуй" компанийг татан буулгасантай холбогдуулж, тус компаний захирал н. Ёндонсүрэнг 1992 оны 12 дугаар сарын 15-наар тасалбар болгон захирлын үүрэгт ажлаас чөлөөлж Монгол-Гонконгийн хамтарсан "Хилько" компанийн мэдэлд шилжүүлсүгэй.

Гурав. "Дугуй" компаний эрх хотын Тээврийн газарт шилжиж байгаатай холбогдуулан Монгол-Гонконгийн хамтарсан "Хилько" компаний дүрмийн санд нийлүүлэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтын "А" заалт, "Дугуй" компаний үндсэн эргэлтийн ба мөнгөн хөрөнгө, өр авлагын жагсаалтыг хавсралтын "Б" заалтын дагуу хотын Тээврийн газрын мэдэлд шилжүүлсүгэй.

Дөрөв. "Дугуй" компаниас электродын хамтарсан үйлдвэр байгуулахаар Казакстаны талтай хамтарч гарын үсэг зурсан гэрээ хэлэлцээрийн нөхцлийг цаашид хүчин төгөлдөр үргэлжлүүлэх бололцоогоор хангаж, үйлдвэр байгуулахаар худалдан авсан байрыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлэхийг хотын Тээврийн газар /н. Дашцэрэн/-т даалгасугай.

Тав. Энэ шийдвэр гарсантай холбогдуулж хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 337 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

[Handwritten signature]

Ц.БААСАНЖАВ



199

Нийслэлийн Засаг даргын 1992
тоот захирамжийн
хавсралт

ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

А. Монгол-Гонконгийн хамтарсан "Хилько"
компаний дүрмийн санд нийлүүлсэн эд
хөрөнгийн үнийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо шир- хэг	Худалдаж авсан анхны үнэ		Хамтарсан компаний дүрмийн санд шинээр нэмж оруулсан үнэ	
			нэг бү- рийн үнэ	бүгд үнэ	нэг бү- рийн үнэ	бүгд үнэ
1.	Үйлдвэрийн байр	1	600,0 м.т	600,0 м.т	2175,6 м.т	2175,6 м.т
2.	Халаалтын зуух	1	45,8 м.т	45,8 м.т	70,0 м.т	70,0 м.т
3.	Гагнуурын аппарат	1	17,0 м.т	17,0 м.т	21,0 м.т	21,0 м.т
4.	Дугуй угсрах ширээ	5			1,5 м.т	7,5 м.т
5.	Сейф /4 хаалгатай/	2	1,3 м.т	2,6 м.т	3600 төг	7200 төг
6.	Сейф	1	1640 төг	1640 төг	3600 төг	3600 төг
7.	Сейф	2	1800 төг	3600 төг	3600 төг	7200 төг
8.	Бичгийн ширээ /2 тум- бочкитай/	3	900 төг	2700 төг	2800 төг	8400 төг
9.	Бичгийн ширээ /1 тум/	5	1500 төг	7500 төг	2000 төг	10000 төг
10.	Урт ширээ	5	500 төг	2500 төг	1000 төг	5000 төг
11.	Хагас зөөлөн сандал	2	264 төг	526 төг	340 төг	680 төг
12.	Хагас зөөлөн санадл	6	250 төг	1500 төг	300 төг	1800 төг
13.	Түшлэггүй сандал	5	40 төг	200 төг	100 төг	500 төг
	ДҮН			685,6 м.т		2318,5 м.т

Б. Дугуй компаний өөрийн хөрөнгө
өр авлага

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Худалдаж авсан үнэ
1.	Конторын байр	1	ш	33,0 мян.төг
2.	Тоосго /улаан/	2000	ш	2,0 мян.төг
3.	Угольник	262	кг	4986 төг
4.	Тоолуур	1	ш	200 төг
5.	Торгон хөшиг	2	хос	400 төг

6.4 хаалгатай сейф	I	ш	1300 төг
7.Ширээ	I	ш	900 төг
8.Урт ширээ	5	ш	2500 төг
9.Хагас зөөлөн сандал	5	ш	1250 төг
10.Мухар сандал	5	ш	200 төг
11.Нэг шүүгээтэй бичгийн ширээ	5	ш	7500 төг
12.Шүүгээ	5	ш	200 төг
13.Хурлын ширээ	2	ш	3322 төг
14.Хагас зөөлөн сандал	I	ш	264 төг
15.Тооцооны харилцахад байгаа үлдэгдэл мөнгөн хөрөнгө /1992.11.27-ны өдрөөр/			228,4 мян.төг
16.Өр төлбөр /өглөг/			
-Өмч хувьчлалын комисст		мян.төг	500,0
-Хотын санхүүгийн хэлтэст		мян.төг	250,0
-Хилько компанид		мян.төг	645,0
17.Авлага			
-Хилько компаниас		мян.төг	174,1

ТАЙЛБАР: Хоёр байгууллагын 1992.11.11-ний өдрийн протоколын дагуу хаягдал зэс, гуулийн төлбөр орж ирсний дараа гэрээнд заасан үнээр, эсвэл үнийн гүйцэтгэлээр тооцож авна.